

**“МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ”-ИЙН
АРГА ХЭМЖЭЭНИЙ 2025 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН ХЭРЭГЖИЛТ**

2025 оны 04 дүгээр сарын 04

Улаанбаатар хот

Д/д	Арга хэмжээ	Төсөв (сая төг)		Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		Зорилтот түвшин		Хэрэгжилт	Хүрсэн түвшин, гүйцэтгэлийн хувь
		Төсөвлөсөн	Гүйцэтгэл /зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)		Он	Түвшин	Он	Түвшин		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	2.7.3.гадаа-дын иргэн, харьяалал-гүй хүн, цагаачдын тооны зохист түвшнийг хадгалах, хяналт тавих тогтолцоог бэхжүүлнэ.	-	-	Гадаадын иргэн, харьяалал-гүй хүн, цагаачдын тооны харьцаа	2024	2024 онд Монгол Улсад цагаачлан оршин суугч нийт 1827 гадаадын иргэн байсан нь Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд заасан хэмжээнээс хэтрээгүй.	2025	Хуулийн хүрээнд зохист түвшний хязгаарыг алдагдуулахгүй байх	Монгол Улсад 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар 1831 гадаадын иргэн, үүнээс хамгийн их буюу БНХАУ-ын 1252 иргэн Монгол Улсад цагаачлан оршин суухаар бүртгэлтэй байгаа нь Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.5 дахь хэсэгт заасан хэмжээнээс хэтрээгүй байна. Монгол Улсад 2009-2012 онд оруулж болох цагаач гадаадын иргэдийн тоо, бүтэц, байршлын тухай УИХ-ын 2009 оны 44 дүгээр тогтоолоос хойш тогтоолыг шинэчлэн батлаагүй бөгөөд Гадаадын иргэн, харьяатын газраас “Монгол Улсад 2021-2024 онд цагаачлуулж болох гадаадын иргэдийн тоо, бүтэц, байршлын тухай” УИХ-ын тогтоолын төсөл, танилцуулгыг 2021 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 01/1730 дугаар, 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 01/2075 дугаар албан бичгээр тус тус Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлж байсан.	100

1	2	3	4	5	6	7	8	9	10	11
									Тус байгууллага нь Гадаадын иргэний талаарх болон Харьяатын тухай хууль тогтоомжийн хүрээнд “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” байгуулж хөтлөн төвд Виз, зөвшөөрлийн газар (виз, зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн-19, үүнээс цагаач хариуцсан ахлах мэргэжилтэн-1, цагаач хариуцсан мэргэжилтэн-4), Зөрчил шалган, шийдвэрлэх газар (хяналтын улсын байцаагч-20) хилийн боомт, орон нутагт нийт 6 газар, 4 хэлтэс (виз, зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн, хяналтын улсын байцаагч-132)-т гадаадын иргэдийн бүртгэлд хяналт тавин ажиллаж байна. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/24 дүгээр тушаалаар баталсан “Салбарын статистик мэдээллийн санг бүрдүүлэх, эрхлэн хөтлөх, ашиглах журам”, байгууллагын даргын 2021 оны А/173 дугаар тушаалаар баталсан “Гадаадын иргэн, харьяатын газрын статистик мэдээллийн санг бүрдүүлэх, хөтлөх журам”-ын дагуу гадаадын иргэдийн бүртгэл, хяналтын мэдээг сар бүр, хагас жил тутам гарган харьцуулсан дүгнэлт хийж дээд шатны байгууллагад тайлагнадаг.	
2	7.2.4.гадаа-дын иргэдийг улсын хилээр нэвтрэх үед биеийн давхцахгүй өгөгдлийг авч, нэгдсэн санд бүртгэх тогтолцоог бүрдүүлнэ.	-	-	Гадаадын иргэн, харьяалалгүй хүний биеийн давхцахгүй өгөгдөл бүхий бүртгэлийн системийн хөгжүүлэлт	2024	Программ хангамж, тоног төхөөрөмжийн тоо-1	2025	Үйл ажиллагаа хэвийн явагддаг болсон байна.	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсэгт “Албан болон хувийн хэргээр оршин суугч гадаадын иргэнд түүнийг харьяалах улсын товчлол, төрсөн он, сар, өдөр, хүйс зэрэг өгөгдлийг багтаасан хоорондоо давхцахгүй бүртгэлийн дугаарыг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага олгоно гэж” заасны дагуу бүртгэлийн системийн хөгжүүлэлтийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс үйл ажиллагаанд нэвтрүүлснээс хойш нийт 798,895 гадаад иргэнд гадаадын иргэний бүртгэлийн дугаарыг олгосон байна.	100

1	2	3	4	5	6	7	8	9	10	11
									2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс Хил хамгаалах байгууллагын системтэй сервис холбосноор гадаадын иргэн хилээр нэвтрэх үед бүртгэлийн дугаар шууд үүсэх боломжтой болсон. 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрөөс Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, И-Монгол академитай хамтран танилт нэвтрэлтийн ДАН системд гадаадын иргэний бүртгэл (F-Register) ашиглан нэвтрэх, тоон гарын үсэг авах боломжийг бүрдүүлсэн. 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар 21 байгууллагад бүртгэлийн дугаарын мэдээллийг төрийн мэдээлэл солилцооны ХҮР системээр дамжуулан өгч байна.	
Үнэлгээ 100 хувь										

--oo0oo--